



ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ

2020 оны 39 болон 40 дэх долоо хоног

ГЛОБАЛ ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТИЙН ТОЙМ


2020 оны 9-р сарын 17-оос 10-р сарын 01-ний байдлаар

Ковид-19 дэлхий нийтээр хурдтай тархаж, цар тахлын түвшинд хүрээд буй өнөөгийн нөхцөлд глобал эдийн засаг, санхүүгийн зах зээлд томоохон өөрчлөлтүүд гарч байна. Эдгээр өөрчлөлтүүд болон эдийн засгийг тогтворжуулахад улс орнуудын авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээний талаар тухай бүр мэдээлж байх зорилгоор Монголбанкнаас долоо хоног тутам бэлтгэн хүргэж буй гадаад орчны тойм мэдээллийн 24 дэх дугаарыг хүргэж байна.

1 ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЖ БУЙ НӨЛӨӨ

- **Roubini Global Economics** байгууллагаас дэлхийн эдийн засаг **2020 онд 4.2 хувиар агших** шинэчилсэн төсөөллийг 9-р сарын 18-нд зарлалаа. Энэ нь 6-р сард хийсэн төсөөллөөс 0.2 нэгж хувиар буурсан төсөөлөл юм. Суурь төсөөлөлд өвлийн улиралд цар тахлын тархалт дахин дэгдэж, хэсэгчилсэн хөл хорио тогтоосноор эдийн засгийн өсөлт оны 2-р хагаст савалгаатай байх, ирэх жилийн зун вакцин гарах, төсөв, мөнгөний бодлогууд эдийн засгийг дэмжихээр таамаглажээ. Суурь төсөөлөлд 2020 онд БНХАУ-ын эдийн засаг 2.1 хувиар өсөх, Евро бүс 8.5 хувиар агших, АНУ-ын эдийн засаг 4.5 хувиар агших, Оросын эдийн засаг 3.0 хувиар агшихаар байна. Харин гутранги хувилбарт зарим орнууд хөл хориог хэт эрт цуцалснаар КОВИД-19-ийн дэгдэлт дахин нэмэгдэж, W хэлбэрийн хямрал ажиглагдах, дэлхийн эдийн засаг 2020 онд 5.0-8.0 хувиар агшин, 2022 оноос алгуур сэргэхэд хүрч болзошгүй гэж үзэж байна.
- Дэлхийн банкнаас “Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн эдийн засгийн төлөвийн тайлан”-г 2020 оны 10-р сард нийтэллээ. Уг тайланд **бүсийн эдийн засаг энэ онд 0.9 хувиар, үүнд**
- **БНХАУ-ын эдийн засаг 2.0 хувиар өсөхөөр төсөөлжээ.** БНХАУ-ын эдийн засгийн өсөлтөд Засгийн газрын зарцуулалт болон экспорт эерэгээр нөлөөлөх бол хэрэглээний сэргэлт алгуур байгаа нь сөргөөр нөлөөлнө гэж үзжээ. Ирэх онд БНХАУ-ын өсөлт 7.9 хувиар, бүс нутгийн бусад эдийн засгийн өсөлт 5 хувиар сэргэхээр төсөөлж байна. **Монголын эдийн засгийн хувьд уул уурхай, үйлчилгээний салбар агшсанаар эдийн засаг энэ онд 2.4 хувиар агших, ирэх 2 жилд хэрэглээ, хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр 5 хувиар өснө гэж Дэлхийн банкнаас төсөөлж байна.** КОВИД-19 цар тахлын улмаас дэлхийн хэмжээнд ядуурлын түвшин сүүлийн 20 жилд анх удаа нэмэгдэж, 38 сая хүн ядуурлын түвшнээс доогуур орохоор байна.
- Oxford Economics байгууллагын 2020 оны 9/10-р сарын эдийн засгийн төсөөллөөр **дэлхийн эдийн засаг 4.4 хувиар агшиж, ирэх онд 5.4 хувиар өсөхөөр** байна (Зураг 1). Сүүлийн саруудын тоон үзүүлэлтүүд эерэг байгаа тул дэлхийн ДНБ 2-р улиралд огцом агшсан хандлага 3-р улиралд эргэж, сэргэлт бий болох хандлагатай байна. Гэсэн ч цар тахлын өмнөх 2019

оны сүүлийн улирлын ДНБ-ий түвшинтэй харьцуулахад 3-р улирлын ДНБ 4 орчим хувиар доогуур байгаа нь дэлхийн санхүү, эдийн засгийн хямралын үеэр ч ажиглагдаагүй том уналт юм.




Зураг 1. Oxford economics байгууллагын дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл, 2020 оны 9-р сарын байдлаар

- **Евро бүсийн** нэгдсэн PMI индекс энэ оны 8-р сард 51.9 байсан бол 9-р сард 50.1 болж **аж үйлдвэрлэл өсөлтгүй байв**¹. Дэд бүлгээр задалж харвал боловсруулах салбарын PMI индекс 8-р сард 51.7 байсан бол 9-р сард 53.7 болж өссөн хэдий ч үйлчилгээний салбарын PMI индекс 8-р сард 51.9 байснаас 9-р сард 47.6 болж буурчээ. Испани, Францын зарим хэсгүүдэд вирусийн тархалт дахин дэгдэж, иргэдийн болгоомжлол нэмэгдсэн нь үйлчилгээний салбарын үйлдвэрлэл буурахад нөлөөлөв.
- IFO институцээс Евро бүсийн эдийн засгийн төлөв, байдлын тайланг 9-р сарын 29-нд нийтэллээ. Уг тайланд **Евро бүсийн эдийн засаг** оны эхний хагаст хүчтэй агшсан ч 3-р улиралд өмнөх улирлаас 15.2 хувиар, 4-р улиралд 1.4 хувиар тус тус нэмэгдэх төсөөлөлтэй буюу энэ онд бүсийн эдийн засаг нийт **8.0 хувиар агшихаар** байна(Зураг 2).. Энэ оны 3-р улиралд эдийн засгийн сэргэлтийг боловсруулах салбарын үйлдвэрлэлийн өсөлт голлон

бий болгохоор байна. Мөн хувийн хэрэглээ сэргэх хэдий ч гадаад эрэлт сул байж, хөрөнгө оруулалтын тодорхой бус байдал үргэлжлэх тул бүсийн хөрөнгө оруулалт удаан сэргэх төлөвтэй гэж үзжээ.

Seasonally and working day adjusted



Source: Eurostat and Ifo-Istat-KOF Forecasts

Зураг 2. IFO институцийн Евро бүсийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл

- McKinsey&Co компанийн 9-р сарын эдийн засгийн нөхцөл байдлын түүвэр судалгаагаар дэлхийн **эдийн засгийн төлөвийн талаарх** хүлээлт өмнөх улирлын түүвэр судалгаанаас **сайжирсан байна**. Хэдийгээр эдийн засгийн нөхцөл байдал 6 сарын өмнөх үеэс муу байгаа хэдий ч 6-р сарын хүлээлттэй харьцуулахад 9-р сард дэлхийн томоохон корпорацуудын захирлууд ирэх 6 сард эрэлт, ашиг нэмэгдэж, эдийн засгийн төлөв сайжрах хүлээлт 3 дахин нэмэгдсэн байна.
- **АНУ-ын үл хөдлөх хөрөнгийн зах хүчтэй байна**. АНУ-ын хуучин үл хөдлөх хөрөнгийн борлуулалт 7-р сард жилийн 2.4 хувиар өссөн бол 8-р сард жилийн 10.5 хувиар өсчээ. Түүнчлэн, шинэ үл хөдлөх хөрөнгийн (байшин, орон сууц) борлуулалт 8-р сард өмнөх оны мөн үеэс 43.2 хувиар өссөн нь урьд өмнө үзэгдээгүй өсөлт юм. Ийнхүү үл хөдлөх хөрөнгийн зах сэргэж байгаа нь санхүүжилтийн өртөг (хүү) бага байгаатай холбоотой. АНУ-ын боловсруулах салбарын PMI индекс энэ

¹ IHS Markit-аас түүвэр судалгаанд суурилан тооцдог PMI индекс нь 50-аас дээш утга авбал тэлэлт, 50-с доош утгатай бол агшилтыг илтгэдэг.

оны 8-р сард 52.7 байсан бол 9-р сард 53.7 болж өссөн, үйлчилгээний салбарын PMI индекс 8-р сард 55.0 байсан бол 9-р сард 54.6 болж өсөлт нь саарчээ. Үйлчилгээний салбарын үйлдвэрлэл өсч байгаа нь дотоод эрэлт болон ажил эрхлэлт нэмэгдэж байгаагийн илрэл гэж шинжээчид үзэж байна.


Эх сурвалж:

1. Reuters, [Metals-Copper hits 1-week low as dollar rebounds, LME inventories rises](#)
2. Reuters, [Oil drops on higher inventories, weak U.S. stock markets](#)

3. Delliote, [Weekly global economic update October 2020](#)
4. Mckinsey, [Economic Condition Snapshot, September 2020: Mckinsey Global Survey results](#)
5. Continuum Economics, [Global Outlook: A Vaccine for Growth](#)
6. World Bank, [From Containment to recovery](#)
7. Montsame, [Mongolia's economic growth to accelerate to over 5 percent in 2021-22, World Bank report finds](#)
8. IFO institute, [Eurozone Economic Outlook: Eurozone GDP starts to recover \(September 2020\)](#)
9. Oxford Economics, [World Economic Prospects](#)
10. J.P.Morgan, [Economic update](#)

2 БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГТ ГАРЧ БУЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Блүүмберг Экономиксийн тооцооллоор БНХАУ-ын эдийн засаг 3-р улиралд хүлээлтэд нийцтэйгээр өмнөх оны мөн үеэс 5.3 хувь, 4-р улиралд 6.1 хувиар тус тус өсөх төлөвтэй(Зураг 3). Цар тахлын эсрэг вакцин хугацаанаасаа эрт нийлүүлэгдлээ ч дэлхий даяар хүрэлцэх хүртээмжээс хамааран БНХАУ-ын эдийн засгийн гадаад эрэлт онцгой өөрчлөгдөж амжихгүй тул ирэх оны төсөөлөлд төдийлөн нөлөөлөхгүй гэж үзсэн байна.



Зураг 3. БНХАУ-ын эдийн засгийн төсөөлөл

- **Аж үйлдвэрлэлийн салбар дахь ашиг 7-р сард 19.6 хувиар нэмэгдсэн бол 8-р сард 19.1 хувиар нэмэгдэж өмнөх**

сараас бага зэрэг буурав (Зураг 4).




Зураг 4. БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбар дахь үйлдвэрлэл, ашиг, ҮҮИ

Харин оны эхний 8 сард аж үйлдвэрлэлийн салбарын орлого өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар буурав. Экспорт 7-р сард 7.2 хувиар өссөн бол 8-р сард жилийн 9.5 хувиар нэмэгдэж компаниудад дэмжлэг болов.

- **Үйлдвэрлэлийн үнийн индекс /ҮҮИ/ 7-р сард жилийн 2.4 хувиар буурсан бол 8-р сард 2 хувиар агшиж бууралт нь багасав. Салбараар нь авч үзвэл боловсруулах үйлдвэрлэлийн ашиг оны эхний 7 сард 4.5 хувиар буурсан бол эхний 8 сард 1 хувиар агшиж бууралт нь багасчээ. Компанийн төрлөөр авч үзвэл**

гадаадын хөрөнгө оруулалттай болон хувийн сектор дахь аж ахуйн нэгжүүдийн ашиг оны эхний 8 сард харгалзан 0.4 хувь, 3.3 хувиар тус тус буурав. Харин төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн ашиг оны эхний 7 сард жилийн 23.5 хувиар буурсан бол эхний 8 сард 17 хувиар агшиж бууралт нь мөн багасав (Зураг 5).



Зураг 5. БНХАУ-ын улсын, хувийн сектор дахь хөрөнгө оруулалт

Автомашин үйлдвэрлэгчид оны эхний 7 сард жилийн 5.9 хувийн алдагдалтай байсан бол эхний 8 сард жилийн 1.5 хувийн ашигтай ажилласан байна.


- **БНХАУ-ын угаасан коксжих нүүрсний нийт үйлдвэрлэл** 8-р сард 42.3 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар нэмэгдсэн бол оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Коксжих нүүрсний эрэлт 8-р сард 49.3 сая тонн хүрч жилийн 3.3 хувиар нэмэгджээ. БНХАУ-ын Шанси мужийн угаасан коксжих нүүрсний нийт үйлдвэрлэл 8-р сард 20.63 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 4.4 хувиар нэмэгдсэн бол оны эхний 8 сард 142.8 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 хувиар өсөв. Харин Шандонг, Гуаизоу, Хэнан мужуудын угаасан коксжих нүүрсний үйлдвэрлэл оны эхний 8 сард харгалзан 36.4 сая тонн, 21.2 сая тонн, 16.7 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 5.8 хувь, 27.1 хувь, 7.4 хувиар тус тус буурлаа. Зөвхөн 8-р сарыг авч үзвэл

Шандонг, Гуйзоу, Хэнан мужийн үйлдвэрлэл 4.39 сая тонн, 1.89 сая тонн, 2.02 сая тонн хүрч өмнөх оны мөн үеэс 4.8 хувь, 38.5 хувь, 5.5 хувиар тус тус буурлаа.

- БНХАУ-ын коксжих нүүрсний импортыг мужуудаар нь хувааж үзвэл Хэбэй, ӨМӨЗО, Гуангши мужийн импорт оны эхний 8 сард өмнөх оны мөн үеэс 4.4 хувь, 47.3 хувь, 34.9 хувиар тус тус буурсан бол Гуангдонг, Лиаонинг мужийн коксжих нүүрсний импорт жилийн 54.3 хувь, 18 хувиар тус тус өсөв. Зөвхөн 8-р сарыг авч үзвэл Хэбэй, Өвөр Монгол, Гуангши, Лиаонинг мужийн импорт өмнөх оны мөн үеэс 37.1 хувь, 25.0 хувь, 48.6 хувь, 3.1 хувиар тус тус буурсан бол Гуангдонг мужуудын импорт 119.4 хувиар өсөв.
- Нүүрсний импортын хориг тавигдаагүй тул 8-р сард **БНХАУ-ын коксжих нүүрсний нийт импорт 7.2 сая тонн болж жилийн 20.9 хувиар буурсан**, оны эхний 8 сард коксжих нүүрсний импорт 52.6 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 0.9 буурсан үзүүлэлттэй байна. БНХАУ-ын Канад, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 8-р сард 0.46 сая тонн, 0.49 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 48.1 хувь, 2.1 хувиар тус тус нэмэгдсэн бол Австрали, Монголоос импортолсон коксжих нүүрсний хэмжээ 3.02 сая тонн, 3.07 сая тоннд тус тус хүрч өмнөх оны мөн үеэс 32.9 хувь, 17.7 хувиар тус тус буурчээ (Зураг 6). Харин оны эхний 8 сард Австрали, Канад Улсуудаас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 31.6 сая тонн, 3.13 сая тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 36.9 хувь, 45.7 хувиар тус тус нэмэгдсэн бол Монгол, ОХУ-аас импортолсон коксжих нүүрсний хэмжээ 12.6 сая тонн, 3.9 сая



тоннд хүрч өмнөх оны мөн үеэс 45.3 хувь, 3.3 хувиар тус тус буураад байна.



Зураг 6. БНХАУ-ын коксжих нүүрсний импорт

Эх сурвалж:

1. China Insight: Recovery on, No waiting for Vaccine, Bloomberg
2. China Coal/Coke Market Monthly, Sep 2020, Sxcoal.com
3. China React: Industrial Profit Growth Strong, Signs of Cresting, Bloomberg
4. China Preview: PMIs to show recovery slowing, still has legs, Bloomberg

3 МОНГОЛБАНК, ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ АРГА ХЭМЖЭЭ

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2021 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-аар хэлэлцүүлэхээр Монголбанкны Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн, УИХ-ын дарга Г.Занданшатарт өнөөдөр өргөн барилаа.

Дотоодын эдийн засагт 2017-2019 онд сэргэлт бий болж тогтворжсон хэдий ч, Ковид-19 цар тахал, түүнээс сэргийлэх арга хэмжээний нөлөөгөөр эдийн засагт оролцогчдын хүлээлт өөрчлөгдөж, бизнесийн үйл ажиллагаа хязгаарлагдаж, иргэдийн амьжиргаанд сөрөг үр дагавар нь мэдрэгдэв. Энэ үед Монголбанк эдийн засгийн уналтаас иргэд, аж ахуйн нэгж, банкны системийг хамгаалах, үүссэн шокийг зөөлрүүлэх зорилгоор i) зах зээл дээрх хөрвөх чадварыг дэмжиж санхүүжилтийн нөхцөлийг зөөлрүүлэх, ii) банкны хяналт шалгалтын журам болон шалгуур үзүүлэлтүүдэд түр өөрчлөлт оруулах, iii) зээлийн эргэн төлөлтийг хойшлуулах зэрэг мөнгөний бодлого, макро зохистой бодлого, микро зохистой бодлогын багц арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж байна. Цаашид Төв банк хуулиар ногдсон үндсэн зорилтуудаа биелүүлэхэд чиглэсэн бодлогын арга хэрэгслээ ашиглаж, цар тахлаас үүдэлтэй эдийн засгийн сорилтыг хохирол багатай даван туулж, эдийн засгийн тогтвортой байдлыг хангахыг зорин холбогдох эрх бүхий байгууллагууд болон олон улсын байгууллагуудтай нягт хамтран ажиллана.

УИХ-д өргөн барьсан төсөлд Төв банк инфляцыг 2021-2023 онд +/-2 нэгж хувийн интервалд 6 хувийн орчимд тогтворжуулах зорилтыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхээр тусгалаа. Монголбанк зах зээлийн зарчимд тулгуурлан үнийн тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлснээр инфляц сүүлийн 3 жилд зорилтот 8%-ийн түвшинд тогтвортой

хадгалагдав. 2006-2016 онд жилийн дунджаар 10% буюу харьцангуй өндөр түвшинд, өндөр хэлбэлзэлтэй байсан инфляцыг ийнхүү тогтворжуулснаар инфляцын зорилтыг бууруулах боломж бүрдлээ. Үүний зэрэгцээ макро зохистой бодлогыг цар тахлаас шалтгаалан эдийн засгийн төлөв, санхүүгийн орчинд бий болсон сөрөг үр дагаврыг зөөлрүүлэх, банкны системийн эрсдэлээс сэргийлэх, санхүүгийн зуучлалыг тасалдуулахгүй байлгах зорилгоор мөнгөний бодлоготой хослуулан хэрэгжүүлнэ. Өмнөх жилүүдэд мөчлөг сөрсөн бодлогоор хэрэглээний зээлийн хэт хурдтай өсөлтийг сааруулж, банкны балансын долларжилтыг бууруулах арга хэмжээ авсан нь эдийн засгийн хүндрэлийн үед үүсэж болзошгүй байсан эрсдэлийг хязгаарлалаа.

Санхүүгийн тогтвортой байдлын хүрээнд, Ковид-19-ийн эдийн засгийн хүндрэлийн үед мөчлөг сөрсөн арга хэрэгслийг ашиглан банкны салбарын эрсдэл даах чадварыг хадгалах, хяналт шалгалтын болон зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, хууль эрх зүйн орчны шинэтгэлийг үргэлжлүүлэх ажлууд төлөвлөгдөөд байна. Цар тахал цаашид хэдий хугацаанд үргэлжлэх нь тодорхой бус хэдий ч 2021 онд Монголбанкны хяналт шалгалтын бодлого i) хүндрэлийг хохирол багатай даван туулж, санхүүгийн зуучлалын тогтвортой байдлыг хангахад чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийн хувилбаруудыг боловсруулж хэрэгжүүлэх, ii) түр хугацааны мөчлөг сөрсөн бодлогын арга хэмжээнүүдээс аажмаар гарах төлөвлөгөөг боловсруулахад чиглэх болно. Үүний зэрэгцээ, банкны зохистой харьцаа, активын ангилал, төлбөрийн чадварын үзүүлэлт болон хяналт шалгалтын хүрээнд тавигддаг шаардлагуудыг Базелийн цуврал стандарттай нийцүүлэн шат дараатай нэвтрүүлэх, эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх суурь шилжилтийг тасралтгүй үргэлжлүүлнэ.



Мөн бие даасан 10 гаруй хуулийг багтаасан “Банкны салбарын хууль, эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ хууль тогтоомжийн давхардал, хийдэл зөрчлийг арилган уялдаа холбоог сайжруулснаар санхүүгийн зах зээл илүү үр ашигтай ажиллах, санхүүгийн байгууллага, хөрөнгө оруулагч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, зах зээлд технологийн дэвшил нэвтэрч шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ бий болох орчныг бүрдүүлэх, санхүүгийн зуучлалыг өргөжүүлэхийг зорих болно.

Төв банк санхүүгийн зах зээлийн дэд бүтцийг хөгжүүлэх, үндэсний төлбөрийн системийн найдвартай, тасралтгүй үйл ажиллагааг хангах, олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дэмжихийн зэрэгцээ УИХ-аас баталсан Зээлийн хүүг бууруулах стратегийг

хэрэгжүүлэх, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог үргэлжлүүлэн сайжруулах, банк, санхүүгийн үйлчилгээний цахим шилжилтийг эрчимжүүлэх зэрэг ажлыг төрийн бусад байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Цаашид Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засагт бий болсон сөрөг нөлөөллийг бууруулах, үүсэж болзошгүй эрсдэлүүдээс сэргийлж, макро эдийн засаг, ажил эрхлэлтийн урт хугацааны тогтвортой байдлыг хангах замаар эдийн засгийн өсөлтийн үр өгөөжийг нэмэгдүүлэхэд макро эдийн засгийн бодлогуудыг чиглүүлэх шаардлагатай тул Монголбанкны ирэх жилүүдийн бодлого, үйл ажиллагаа энэхүү зорилтыг хангахад чиглэнэ.



4 МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД

- Төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхнээс **3.8%**, өмнөх оны мөн үеэс **7.0%**-иар сулраад байна /2020.10.01-ний байдлаар/.
- ТОП-20 индексийн үзүүлэлт **17,532** болж өмнөх оны мөн үеэс 9.9%-иар буураад байгаа боловч сүүлийн 14 **хоногийн** хугацаанд харьцангуй тогтвортой байна /2020.10.01-ний байдлаар/.

14 ХОНОГИЙН МЭДЭЭ						
ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе	Өөрчлөлт	Өсөлт
		/2020.10.01/	/2020.09.17/	/2019.10.01/	/2020.09.17- /2020.10.01/	/өмнөх оны мөн үе/
Валютын урсгал болон ханш						
Ам.долларын ханш	₮	2,854.7	2,854.6	2,667.1	0.2	7.0%
Хөрөнгийн зах						
ТОП-20 индекс		17,531.6	17,154.7	19,457.5	377.0	-9.9%
МУ-ын бондуудын өгөөж						
Монгол 2021 - МАЗААЛАЙ	%	4.0	4.2	5.2	-0.3	-23.3%
Монгол 2022 - ЧИНГИС	%	4.0	4.2	5.0	-0.2	-21.5%
ХХБ САМУРАЙ	%	1.1	1.1	0.6	0.0	79.6%
Монгол 2024 - Хуралдай	%	4.9	4.9	5.6	0.0	-13.7%
Монгол 2023 - Гэрэгэ	%	4.3	4.3	5.2	0.0	-17.4%
МУХБ	%	5.6	5.4	6.3	0.1	-11.6%
МИК	%	11.9	12.0	10.4	-0.1	14.2%

Тайлбар: Хүснэгтэд 2020 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн байдлаарх хамгийн сүүлийн үеийн тоон мэдээг тусгасан бөгөөд зарим тоон мэдээ нь яг тус өдрийнх биш байна.


Хөрөнгийн зах /2020.10.01/:

Зураг 1. Хөрөнгийн биржийн Тор-20 индекс



Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

Зураг 2. МУ-ын бондуудын өгөөж (%)



Эх сурвалж: Монголбанк



ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ СУУРЬ ӨӨРЧЛӨЛТҮҮД


- 2020 оны 9 дүгээр сарын 15-ны байдлаар гадаад худалдааны эргэлт **8,526.2 сая ам.доллар** гарч, тэнцэл **1,105.1 сая ам.долларын ашигтай** гарлаа.
- Зөвхөн 9 дүгээр сарын эхний 15 хоногт 336.8 сая ам.долларын экспорт, 257.4 сая ам.долларын импорт хийсэн байна.

ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД	Нэгж	САРЫН МЭДЭЭ				
		Тайлант үе	Өмнөх үе	Өмнөх оны мөн үе	Өөрчлөлт /2020.08.30- /2020.09.15/	Өсөлт /өмнөх оны мөн үе/
		/2020.09.15/	/2020.08.30/	/2019.09.15/		
Гадаад худалдаа*						
Худалдааны эргэлт	сая \$	8,526.2	7,932.1	9,991.9	7.5%	-14.7%
Экспорт	сая \$	4,815.7	4,478.9	5,661.1	7.5%	-14.9%
Импорт	сая \$	3,710.6	3,453.2	4,330.8	7.5%	-14.3%
Худалдааны тэнцэл	сая \$	1,105.1	1,025.7	1,330.3	7.7%	-16.9%

*Гадаад худалдааны мэдээ нь 15 хоног бүр шинэчлэгдэж байна.


Гадаад худалдаа /2020.09.15/:

Зураг 3. Гадаад худалдааны эргэлтийн өсөлт, сараар



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Зураг 4. Экспорт, импорт, тухайн сараар





Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

5

МОНГОЛ УЛСЫН ЭКСПОРТЫН ГОЛ ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ӨӨРЧЛӨЛТ

Бодит гүйцэтгэл							Товч тайлбар
	Үнэ (-1 day) 2020/09/30	Өөрчлөлт					
		daily	weekly	monthly	year to date	YoY	
Зэс	6668	-4.4%	-2.3%	-5.0%	3.4%	12.7%	БНХАУ-ын хаягдал зэсийн импорт буурах төлөв, ам.доллар чангарсан, нөөц буурсан нөлөөгөөр үнэ өмнөх долоо хоногийн түвшнээс буурахад нөлөөлөв.
Коксжих нүүрс	138.0	-	-	0.0%	-6.2%	-23.2%	Худалдааны маргаан, КОВИД-19-ийн нөлөөгөөр эрэлт нэмж буурах төлөв болон БНХАУ-ын дотоодын үйлдвэрлэл нэмэгдэх төлөв, нөөц хадгалагдсан нөлөөгөөр үнэ бага түвшинд хадгалагдаж байна.
Төмрийн хүдэр	117.9	0.0%	-0.1%	-6.6%	27.4%	24.7%	БНХАУ-ын гангийн үйлдвэрлэлийн идэвхжил үргэлжилж, эрэлт хадгалагдсаны зэрэгцээ цар тахлын улмаас Бразилын нийлүүлэлт хэвийн түвшинд хүрээгүй тул үнэ бага зэрэг буурав.
Алт	1885.8	1.1%	2.0%	-3.3%	24.7%	27.1%	Дэлхийн эдийн засгийн тодорхой бус байдал өндөр, хөгжингүй орнуудад мөнгөний тэлэх бодлогууд үргэлжилж байгаа тул аюулгүй хөрөнгө оруулалтад тооцогддог алтны эрэлт өндөр байна.
Газрын тос (Брент)	40.9	0.0%	-2.4%	-10.2%	-38.2%	-30.5%	АНУ-ын агуулахууд дахь нөөц хүлээлтээс өндрөөр 2.2 сая баррелиар нэмэгдсэн, КОВИД-19-ийн тархалт буурахгүй нэмэгдсээр буй нөлөөгөөр эрэлт буурах төлөв хадгалагдаж үнэ өмнөх долоо хоногоос буурав.



Эх сурвалж: Блүүмберг